

2. Аймаг нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба хураасан үнэт зүйл, үнэт металл, эрдэнийн чулуу, гадаад валютыг заавал банкинд хадгалуул гэж шахаж шаарддаггүй.

3. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явц удааширсан, бага үнэлгээтэй эд зүйл, валют хураагдсан нөхцөлд хадгалалтынхаа зардлыг төлж дийлэхгүй хураагдах магадлалтай. Иймд энэхүү хуулийн заалтыг дагасан журмыг яаралтай батлах, хуулийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.



Б.БОЛОР-ЭРДЭНЭ

ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, ахлах дэслэгч

ХҮҮХДИЙН ТЭТГЭЛЭГ ГАРГУУЛАХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ЧИГ ХАНДЛАГА

Гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын хамрах асуудлын хүрээнд тэжээн тэтгэх, тэр дундаа хүүхдийг тэтгэхтэй холбогдсон харилцаа онцгой байр суурийг эзэлдэг. Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.11-д “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх – нялхас, хүүхдийн эрх ашиг сонирхлыг төр хамгаална гэж заажээ.¹²⁶”

Монгол улсад хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг Үндсэн хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль болон бусад эрх зүйн баримт бичгээр зохицуулдаг. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 нас хүртэл хамгаалахад энэ хуулийн үйлчилдэг.

¹²⁶ Монгол Улсын Үндсэн хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн

Энэ хуулиар хүүхдийн хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох, хүүхдийн эрхийг хамгаалахад төр, олон нийт, иргэд, байгууллагын оролцоо, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг, хүүхдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний талаар нарийвчлан зохицуулсан.

Мөн тус хуулийн 25 дугаар зүйлд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын талаар заасан зохицуулалтын 4 дэх хэсэгт: Хүүхдийн тэтгэлэг төлөхөөс зайлсхийсэн иргэнээр төлбөл зохих тэтгэлгийг төлүүлж, түүнийг 50000 хүртэл төгрөгөөр торгох буюу 30 хүртэл хоногоор баривчлахаар заажээ.

Гэр бүлийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д “Эцэг, эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй.”¹²⁷ Тэжээн тэтгэх харилцаа нь эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэх, төрөл, садангийн хүний тэжээн тэтгэх, насанд хүрсэн хөдөлмөрийн чадвартай хүүхдийн эцэг, эхээ тэжээн тэтгэх гэсэн үүргүүдэд хуваагддаг.

Хүүхдийг тэжээн тэтгэхтэй холбогдсон харилцаа үүсэх хууль зүйн үр дагавар нь гэрлэлт дуусгавар

болсонтой холбоотойгоор үүсдэг. Гэрлэлтийг дараах тохиолдолд дуусгавар болгохоор хуульчилсан¹²⁸.
Үүнд:

1. Гэрлэгч нас барсан болон түүнийг нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн,

2. Гэрлэлтийг захиргааны буюу шүүхийн журмаар цуцалсан, эсхүл хүчин төгөлдөр бус гэж тооцсон дуусгавар болно.

Гэрлэлтийг захиргааны журмаар цуцлахад бол гэрлэлт гэрлэгчид нь гэрлэлтээ цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн, 18 хүртэлх насны хүүхэдгүй, эд хөрөнгийн маргаангүй гэрлэгчдийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн 30 хоногийн дотор гэр бүлийн бүртгэлийн байгууллага гэрлэлтийг цуцалдаг.

Харин бусад тохиолдолд шүүхийн журмаар шийдвэрлэдэг. Дээрх нөхцөлөөр гэрлэлтийг захиргааны журмаар цуцалхаас гадна дараах 2 тохиолдолд захиргааны журмаар гэрлэлтийг цуцлаж болно¹²⁹.

➤ Гэрлэгчдийн аль нэг нь 3 жилээс дээш хугацаагаар хорих ялаар шийтгүүлсэн бол нөгөө тал нь гэрлэлтээ цуцлуулах өргөдлөө гаргаж болох бөгөөд хорих ял эдлэх болсныг гэрчлэх шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг үндэслэн сум дүүргийн засаг дарга гэрлэлтийг цуцалж болно.

➤ Гэрлэгчдийн аль нэгийг шүүхээс иргэний эрх зүйн бүрэн

¹²⁷ Гэрлэгсдийн хэн нэг нь гэрлэлтээ цуцлуулах болон гэрлэлт хүчин төгөлдөр бус болсонд тооцогдохоос өмнө, эсхүл гэрлэлтээ цуцлуулснаас хойш нэг жилийн дотор хөдөлмөрийн чадвараа түр алдсан нь гэр бүлийн хүчирхийлэл болон гэрлэлт цуцлахаас өмнө болсон нөхцөл байдалтай шууд холбоотой үүссэн, хүндэтгэх шалтгааны улмаас хөдөлмөр эрхлэх боломжгүй болсон, гэрлэлт цуцлахаас өмнө тэтгэвэрт гарсан бол салсан нөхөр буюу эхнэрээрээ тэжээн тэтгүүлэх эрхтэй.

¹²⁸

<http://www.legalinfo.mn/law/details/226?lawid=22>

⁶

¹²⁹ С.Боловсон. Гэр бүлийн эрх зүй. 2006 он. 58-р тал

чадамжгүй гэж тооцсон бол эхнэр нөхрийн аль нэгний хүсэлтээр шүүхийн шийдвэрийг үндэслэн захиргааны журмаар гэрлэлтийг цуцалж болдог байна.

Гэр бүлийн харилцаа дуусгавар болоход хүүхдийг тэжээн тэтгэх, асран хамгаалах асуудал үүсэх бөгөөд хүүхдийг эрүүл аюулгүй, сурч боловсрох, эрүүл өсөн торних бололцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэх зэрэг олон хүчин зүйлсийг харгалзан асран хамгаалагчийг томилдог. Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д Хүүхэд долоо ба түүнээс дээш настай бол асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд түүний саналыг харгалзан үзнэ гэж заасан.

Тэжээн тэтгэх харилцаа нь амины шинжтэй, хариу төлбөргүй, харьцангуй удаан үргэлжилсэн байдгийн дээр тэжээн тэтгэх үүргээ бусдад шилжүүлэх, эрх залгамжлуулах тухай асуудал байдаггүй.

Гэр бүлийн тухайн хуулийн 26 дугаар зүйлд: Хүүхдээ хүмүүжүүлэх эрх, үүргийг зааж өгсөн байдаг. Энэ зүйлийн 26.2-т эцэг, эх хүүхдээ хүмүүжүүлэхэд тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ гээд

1. хүүхдээ эрүүл чийрэг өсгөн бойжуулах, сэтгэхүйн хувьд төлөвшүүлэх,

2. хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх,

3. хүүхдээ үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх үзлээр хүмүүжүүлэх, түүнд суурь боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн анхны дадлага олгох гэж заасан байна.

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаа нь иргэний шийдвэр гүйцэтгэлийн бусад ажиллагаанаас дараах онцлогоор ялгагдана.

❖ Хүүхдийн тэтгэлэг нь сар бүр тодорхой мөнгөн дүнгээр төлөгдөж байдаг.

Хүүхдийн тэтгэлэг нь хүүхдийн насны байдлаас хамааран өөрчлөгддөг.

❖ Хүүхдийн тэтгэлэгийг шүүхээс тогтоосон бол жил бүрийн амьжиргааны түвшнээс хамааран өөрчлөгдөж байдаг.

❖ Хүүхдийн тэтгэлэгийн мөнгөнөөс өөр төлбөрийг суутгахыг хориглодог.

❖ Хүүхдийн тэтгэлэг бусад бүх төлбөрөөс тэргүүн ээлжинд төлөгддөг.

❖ Хүүхдийн тэтгэлэгийн мөнгөнөөс урамшуулап тооцохыг хориглодог ба зардлаас чөлөөлдөг.

❖ Хүүхдийн тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь хэрэв тэтгэлэг төлөгч хэд хэдэн төлбөр авагчид төлбөр төлөх үүрэг хүлээсэн бол хүүхдийн тэтгэлэгийг дараалал харгалзахгүй тэргүүн ээлжинд олгоно.

Хүүхдийн тэтгэлийг гаргуулах ажиллагаа нь иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зарчим, процессын дагуу явагддаг. Шийдвэр гүйцэтгэгч хүүхдийн тэтгэлэгийн материалыг хүлээн авмагц хувийн хэрэг нээн тэтгэлэг төлөгчид тэтгэлэг төлөх хугацаатай мэдэгдэлийг дуудан ирүүлж гардуулах, эсвэл баталгаат шуудангаар хүргүүлнэ.

Тэтгэлэг төлөгч заасан хугацаанд тэтгэлэгийг төлөөгүй буюу биелүүлэхээс татгалзвал шийдвэр гүйцэтгэгч шийдвэрийг албадан

биелүүлэхээр дараах арга хэмжээ авна.

Үүнд:

1/ тэтгэлэг төлөгчийн хөрөнгө, биед үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах, худалдан борлуулах;

2/ тэтгэлэг төлөгчийн цалин, бусад орлогоос суутгал хийлгүүлэх;

3/ тэтгэлэг төлөгчийн бусдад байгаа эд хөрөнгө, мөнгөнөөс төлбөр гаргуулах;

4/ тэтгэлэг төлөгчийн банк дахь хадгаламжийн болон харилцах дансанд хасалт хийх

5/ хуульд заасан бусад арга хэмжээ.

Бусад төрлийн төлбөр гаргуулах ажиллагаанаас ялгагдаж буй дээрх онцлогуудаас харвал хүүхдийн эрх ашгийг төрөөс хамгаалж буйн нэгэн илрэл гэж үзэж болно. Тэтгэлэгийг төлбөр төлөгч, төлбөр авагч нар харилцан тохиролцож мөнгөн ба эд хөрөнгийн хэлбэрээр барагдуулж болно. Хэрэв эд хөрөнгийн хэлбэрээр барагдуулах бол тэтгэлэгт тооцох эд хөрөнгийг тэтгэлэг төлөгч, авагч талууд харилцан тохиролцох буюу тохиролцоогүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тухайн үеийн зах зээлийн ханшаар үнэлж тэтгэлэг авагчид олгоно.

Бусад төрлийн төлбөрийг гаргуулахдаа төлбөр төлөгч иргэний өмчлөлийн эд хөрөнгө болох бэлэн мөнгө банк бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө үнэт цаас түүнчлэн хөдлөх ба үл хөдлөх хөрөнгөнөөс гаргуулдаг.

Өөрөөр хэлбэл, төлбөр төлөгчийн эд хөрөнгөнөөс төлбөр гаргуулах

дараалал нь

-бэлэн мөнгө

-банк, банк бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө

-банк, банк бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа үнэт цаас

-Төлбөр төлөгчийн хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө байна.

Дээрх эд хөрөнгө төлбөрийг төлөхөд хүрэлцэхгүй бол төлбөр төлөгчийн дундаа хэсгээр болон хамтран өмчлөх эд хөрөнгийн түүнд оногдох хэсгээс төлбөрийг гаргуулна.

Харин хүүхдийн тэтгэлэгийг тэтгэлэг төлөгчийн дараах орлогоос гаргахыг хориглодог. Үүнд¹³⁰:

-Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гэнэтийн аюул, онцгой байдлын улмаас үзүүлж буй тусламж, хандив

-Илүү цагийн хөлс, нэг удаагийн урамшил, ажлаас халагдсаны хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны Донор болон эхийн сүүнд олгож буй нөхөн олговрын мөнгө

-Нэмэгдэл хоол, амралт сувиллын эмчилгээ, хиймэл эрхтэн хийлгэхэд олгосон зардал

-Тахир дутуугийн тэтгэвэр

Хүүхдийн тэтгэлэгийн мөнгөнөөс бусад орлогоос төлбөр гаргуулж болдог.

Гэхдээ шүүхийн шийдвэрийн үндсэн тэтгэвэр, тэтгэмжээс төлбөр гаргуулж болдог. Уг харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр,

¹³⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2002 он. 56 дугаар зүйл

тэтгэмжийн тухай¹³¹ хуулийн 29 дүгээр зүйлд заасан. Тэтгэвэр, тэтгэмжээс дараах тохиолдолд суутгал хийж болно.

1/ Тэтгэвэр, тэтгэмж авагч хуурамч бичиг баримт бүрдүүлснээс болон энэ хуулийн 28 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үүргээ өөрийн буруугаас болж биелүүлээгүйгээс үндэслэлгүй буюу илүү авсан тэтгэвэр, тэтгэмжийг төлүүлэх тухай шүүхийн эсхүл нийгмийн даатгалын байгууллагын шийдвэр гарсан бол;

2/ Тэтгэвэр, тэтгэмж авагчийн төлбөл зохих энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас бусад төлбөрийг түүний тэтгэвэр буюу тэтгэмжээс нь төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсан бол суутгал хийж болно.

Гэр бүлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд тэтгэлэг олгох хэлбэр, хугацааг дараах байдлаар зохицуулсан байна.

41.1. Тэтгэлгийг дор дурдсан хэлбэрээр олгож болно.

41.1.1. мөнгөн хэлбэрээр;

41.1.2. эд хөрөнгөөр.

41.2. Тэтгэлгийг дараах хугацаагаар олгож болно:

41.2.1. сар, улирал, хагас жил, жилээр;

41.2.2. нэг удаа.

41.3. Тэтгэлгийг хариуцагчийн цалин хөлснөөс суутгал хийх буюу хамтран өмчлөх эд хөрөнгөөс оногдох хэсгийг тодорхойлох үед болон бусад байдлаар олгож болно гэжээ.

Шийдвэр гүйцэтгэгч нь тэтгэлэг

төлөгчийн ажиллаж байгууллага, хуулийн этгээд, эрх бүхий албан тушаалтанд цалин орлогоос суутгал тухай мэдэгдлийг хүргүүлдэг.

Мэдэгдэлд суутгал хийх тухай хувь хэмжээ болон суутгал хийгээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж бичих ба мэдэгдэл хүлээн этгээд нь суутгалыг хийж мөнгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд төвлөрүүлдэг.

Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчөөс бэлэн мөнгө хүлээн авахдаа хүлээн авах, мөн хураан авсан мөнгийг төлбөр авагчид олгохдоо тусгай дугаартай нэгдсэн маягтанд баримтыг ямар нэгэн засваргүйгээр 2 хувь үйлдэж, үйлдсэн огноог бичиж, гарын үсэг зуруулан, төлбөр төлөгчид 1 хувийг өгч, 1 хувийг нь хувийн хэрэгт хавсаргадаг. Шийдвэр гүйцэтгэгч нь хүлээн авсан бэлэн мөнгийг төв суурин газарт 24 цагийн, хөдөө орон нутагт 7 хоногийн дотор төлбөр авагчид олгох буюу шийдвэр гүйцэтгэх албаны дансанд шилжүүлэх бөгөөд гадаад валютын ханшийг шүүхийн шийдвэр гарсан өдрийн Монгол банкнаас зарласан албан ёсны ханшаар бодож олгодог.

Харин хүүхдийн тэтгэлгийн мөнгийг олгоход тэтгэлэг төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос суутгал хийсэн иргэн, хуулийн этгээд түүнийг төлбөр авагчид бэлнээр олгох буюу хадгаламжид нь шилжүүлдэг, эсхүл шийдвэр гүйцэтгэх албаны дансаар дамжуулан олгож болох бөгөөд орж ирсэн тэтгэлгийн мөнгийг банкаар дамжуулан тэтгэлэг авагчид бэлнээр

¹³¹

<http://www.legalinfo.mn/law/details/383?lawid=38>

3

олгох буюу түүний хадгаламжийн дансанд, эсхүл өөрийнх нь заасан дансанд шилжүүлэн олгодгоороо онцлогтой.

Хэрвээ тэтгэлэг төлөгч нь ямар нэг цалин орлогогүй тохиолдолд төлбөр гаргуулах дарааллыг баримтлан төлбөрийг гаргуулна.

Хүүхдийн тэтгэлэг төлөхөөс санаатайгаар зайлсхийх, хугацаанд нь төлөөгүйн хариуцлагыг хууль тогтоомжид хэрхэн тусгасныг үзвэл:

1. Эрүүгийн хуулийн¹³² 120 дугаар зүйлд: Эцэг, эх, эхнэр, нөхөр, төрүүлсэн буюу үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийх

“Хөдөлмөрийн чадваргүй эцэг, эх, эхнэр, нөхөр, төрүүлсэн болон үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэх талаар гарсан шүүхийн шийдвэр биелүүлэхээс ноцтой зайлсхийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.”

*Тайлбар: Энэ зүйлд заасан гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон, яллагаагаар татагдсан, ял шийтгэгдсэн этгээд шүүхийн шийдвэрийг биелүүлсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.*¹³³

Хүүхдийн тэтгэлэгийн төлбөр барагдуулах шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь удааширч байгаа шалтгаан нь доорх хүчин зүйлс нөлөөлөж байгаагаас тэтгэлэг төлөгдөхгүй удааширч, хүүхдийн эрх

ашиг зөрчигдөх асуудал гарч байгаа юм. Үүнд:

1. Төлбөр төлөгчийн хаяг тодорхойгүй

2. Төлбөрийн чадваргүй / ажил, хөдөлмөр эрхэлдэггүй /

3. Тэтгэлэг төлөгч ял эдэлж байгаа

4. Эрэн сурвалжлагдаж байгаа

5. Эд хөрөнгөө бусдад шилжүүлэх зэргээс хамааран төлбөр авагч болон түүний төлөөлөгч нар өргөдөл, гомдол гаргах үндсэн нөхцөл нь болж байгаа юм. Хэдийгээр шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хууль, журмын хүрээнд явагдаж байгаа ч дээрх хүчин зүйлээс хамааран удааширч байгаа юм.

Мөн 1 шийдвэр гүйцэтгэгчид ноогдох гүйцэтгэх баримт бичгийн тоо их байгаагаас нийт гүйцэтгэх баримт бичигт бүрэн хүрч ажиллаж чадахгүй байдал үүсч байгаа юм. Нөгөө талаас хархад одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Гэр бүлийн тухай хуулийн эрх зүйн зохицуулалт буруугаас зарим төлбөр төлөгч нарт тэтгэлэг төлөхөд хэцүү байдал гардаг. Жишээ нь: 1 хүүхдийн тэтгэлэг төлдөг төлбөр төлөгч 3 хүүхэдтэй байхад 1 хүүхдийн тэтгэлэгийн асуудлаас 3 хүүхдийн эрх ашиг хөндөгдөж байгаа нь эрх зүйн орчныг сайжруулах зайлшгүй болсныг харуулж байна.

Тэтгэлэг төлөхөөс зайлсхийсэн төлбөр төлөгчид хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг хууль эрх зүйн орчноор нь сайжруулан өгөх хэрэгтэй юм.

Санал:

1. Хаяг тодруулах ажиллагааг боловсронгуй болгох, шийдвэр

¹³²

<http://www.legalinfo.mn/law/details/50?lawid=50>

¹³³ Улсын дээд шүүхийн 2009.06.24-ний өдрийн 22 дугаар тогтоол

гүйцэтгэгчид нуугдмал эд хөрөнгө илрүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулах

2. Хүүхдийн тэтгэлгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар шийдвэр гүйцэтгэгч нарыг дадлагажуулах нэгдсэн сургалтыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулах

4. Тэтгэлэг төлөхөөс зайлсхийж байгаа төлбөр төлөгч нарт хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох зэрэг саналтай байна